



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/124/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитор Л.Соёлмөнх Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.06.25 № 103
танай _____ -ны № _____ -т

ЦАХИР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА М.ГЭРЭЛТ-ОД ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	60,081,964.46	111,229,568.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	25,814,512.50
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	25,814,512.50
31210	Төгрөг	0.00	25,814,512.50
31211	Төрийн сангийн харилцах	0.00	4,002,812.50
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	21,811,700.00
33	АВЛАГА	0.00	18,578,100.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	18,578,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,081,964.46	66,836,956.20
35100	Түүхий эд материал	25,445,126.96	31,643,766.70
35110	Тусгай зориулалттай материал	4,489,300.00	6,827,740.49
35130	Эм боох материал	20,955,826.96	24,816,026.21
35400	Хангамжийн материал	34,636,837.50	35,193,189.50
35410	Бичиг хэргийн материал	1,520,820.00	1,116,300.00
35420	Аж ахуйн материал	31,872,517.50	32,455,689.50
35440	Түлш, шатах тослох материал	1,070,000.00	1,505,000.00
35460	Хүнсний материал	173,500.00	116,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	292,010,365.65	292,602,738.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	292,010,365.65	292,602,738.53
39200	Биет хөрөнгө	282,510,365.65	283,402,738.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	270,211,547.18	270,211,547.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-71,164,754.39	-75,383,150.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,679,556.00	73,679,556.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,110,721.25	-34,318,110.25
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	113,315,100.52	132,724,804.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,143,898.94	-83,891,677.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,005,832.00	10,005,832.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,282,295.47	-9,626,062.29
39300	Биет бус хөрөнгө	9,500,000.00	9,200,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,000,000.00	8,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	352,092,330.11	403,832,307.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	352,092,330.11	403,832,307.23
51	Засгийн газрын хувь оролцоо	352,092,330.11	403,832,307.23
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	238,315,520.04	238,315,520.04
51200	Хуримтлагдсан үр дүн	-4,124,038.73	47,615,938.39
51210	Өмнөх үеийн үр дүн	-445,830.77	-4,124,038.73
51220	Тайлант үеийн үр дүн	-3,678,207.96	51,739,977.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,900,848.80	117,900,848.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	352,092,330.11	403,832,307.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	462,935,360.02	825,288,676.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,228,960.02	218,562,576.35
120	Нийтлэг татварын бус орлого	65,228,960.02	218,562,576.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,152,556.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,152,556.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	17,103,703.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	35,076,404.02	201,458,872.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,706,400.00	606,726,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386,412,000.00	427,361,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	386,412,000.00	427,361,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,144,400.00	167,414,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,144,400.00	148,836,600.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	18,578,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,150,000.00	11,950,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,150,000.00	11,950,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	445,369,987.98	773,548,699.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,369,987.98	773,548,699.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,523,113.98	744,148,699.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,730,266.00	379,111,512.00
210101	Үндсэн цалин	178,061,066.00	171,980,883.90
210102	Нэмэгдэл	71,275,200.00	160,715,872.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	0.00
210104	Урамшуулал	16,850,000.00	18,457,579.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	27,957,176.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,628,934.00	41,312,278.50
210201	Тэтгэврийн даатгал	21,142,134.00	29,800,801.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,621,700.00	2,200,778.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,097,400.00	2,482,899.00
210204	Ажилгүйдлийн даатгал	524,300.00	620,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,243,400.00	6,207,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,850,000.00	10,174,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,837,500.00	3,023,000.00
210302	Түлш, халаалт	6,000,000.00	7,001,000.00
210303	Цэвэр, бохир ус	12,500.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,762,260.00	38,438,155.00
210401	Бичиг хэрэг	1,683,210.00	3,170,370.00
210402	Тээвэр, шатахуун	18,727,000.00	29,347,557.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,074,750.00	1,007,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,237,300.00	4,812,278.00
2105	Нормативт зардал	39,078,832.06	246,476,723.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,192,165.06	233,172,798.05
210502	Хоол, хүнс	6,447,667.00	11,264,725.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,439,000.00	2,039,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	759,900.00	2,091,850.00

Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,308,000.00
210604	Урсгал засвар	759,900.00	783,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,375,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,656,026.00	1,087,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,556,026.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	87,950.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,256,895.92	24,081,230.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,635,890.00	5,263,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,621,005.92	18,817,330.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,846,874.00	29,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	29,400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,846,874.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,846,874.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	17,565,372.04	51,739,977.12
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,243,580.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	21,243,580.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,678,207.96	51,739,977.12

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,315,520.04	121,372,410.80	-3,917,392.77	355,770,538.07
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	3,471,562.00	3,471,562.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,315,520.04	121,372,410.80	-445,830.77	359,242,100.07
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-3,471,562.00	0.00	-3,471,562.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,678,207.96	-3,678,207.96
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	-4,124,038.73	352,092,330.11
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	-4,124,038.73	352,092,330.11
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	-4,124,038.73	352,092,330.11
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	51,739,977.12	51,739,977.12
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	47,615,938.39	403,832,307.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	397,706,400.00	588,148,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,706,400.00	588,148,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386,412,000.00	427,361,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	386,412,000.00	427,361,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,144,400.00	148,836,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,144,400.00	148,836,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,150,000.00	11,950,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,150,000.00	11,950,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	397,706,400.00	560,027,487.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,706,400.00	560,027,487.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,859,526.00	530,627,487.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,966,300.00	379,664,753.00
210101	Үндсэн цалин	174,297,100.00	168,500,000.00
210102	Нэмэгдэл	71,275,200.00	156,308,353.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	0.00
210104	Урамшуулал	16,850,000.00	21,376,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	33,480,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,392,900.00	40,759,037.50
210201	Тэтгэврийн даатгал	24,906,100.00	28,344,737.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,621,700.00	3,103,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,097,400.00	2,482,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	524,300.00	620,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,243,400.00	6,207,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,850,000.00	10,650,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,837,500.00	4,500,000.00
210302	Түлш, халаалт	6,000,000.00	6,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	12,500.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,353,800.00	37,013,357.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,647,000.00	29,306,557.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	1,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	3,300,000.00
2105	Нормативт зардал	19,528,100.00	50,409,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,878,100.00	36,101,500.00
210502	Хоол, хүнс	5,750,000.00	12,408,490.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,900,000.00	1,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	2,475,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,194,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,281,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,375,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,656,026.00	1,087,950.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,556,026.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	87,950.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,012,400.00	7,192,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,012,400.00	7,192,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,846,874.00	29,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	29,400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,846,874.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,846,874.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	28,120,512.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	2,306,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	2,306,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	2,306,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	2,306,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-2,306,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	25,814,512.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	25,814,512.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	439,311,400.00	435,308,587.50	4,002,812.50	99.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	439,311,400.00	435,308,587.50	4,002,812.50	99.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,311,400.00	435,308,587.50	4,002,812.50	99.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,356,400.00	310,356,400.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	168,500,000.00	168,500,000.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	87,000,000.00	87,000,000.00	0.00	100.00
210104	Урамшуулал	21,376,300.00	21,376,300.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,480,100.00	33,480,100.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,898,200.00	40,759,037.50	1,139,162.50	97.28
210201	Тэтгэврийн даатгал	29,483,900.00	28,344,737.50	1,139,162.50	96.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,103,600.00	3,103,600.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,482,900.00	2,482,900.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	620,700.00	620,700.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,207,100.00	6,207,100.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,650,000.00	10,650,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.00

Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,206,800.00	29,206,800.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	21,500,000.00	21,500,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	29,900,000.00	29,900,000.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,500,000.00	20,500,000.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,900,000.00	1,900,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,800,000.00	4,781,000.00	19,000.00	99.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,281,000.00	19,000.00	98.54
2107	Томилот, зочны зардал	3,300,000.00	1,375,000.00	1,925,000.00	41.67
210702	Дотоод албан томилот	3,300,000.00	1,375,000.00	1,925,000.00	41.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	1,087,950.00	112,050.00	90.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	0.00	80,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	87,950.00	32,050.00	73.29
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	750,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,192,400.00	807,600.00	89.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,192,400.00	807,600.00	89.91
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	439,311,400.00	439,311,400.00	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	427,361,400.00	427,361,400.00	0.00	100.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	427,361,400.00	427,361,400.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,950,000.00	11,950,000.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	11,950,000.00	11,950,000.00	0.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,002,812.50	4,002,812.50	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.00

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	127,024,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,024,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,624,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,308,353.00
210102	Нэмэгдэл	69,308,353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,806,557.00
210402	Тээвэр, шатахуун	7,806,557.00
2105	Нормативт зардал	20,509,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,601,500.00
210502	Хоол, хүнс	4,908,490.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	148,836,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,836,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	148,836,600.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	21,811,700.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,811,700.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цахир сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлэх хүрээний хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвдсөн үед эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанартай, хүртээмжтэй үзүүлж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлж мэдээлэл сургалт сурталчилгааг хүртээмжтэй чанартай тогтмол зохион байгуулж хувь хүн, гэр бүл, хамт олны идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилготой нийгмийн болон эмнэлгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Удирдлагын багмыг чадавхижуулах
- ✓ Эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах
- ✓ Ажилчдын нийгмийн хамгаалал, сургалтын хөтөлбөрийг боловсруулах
- ✓ Барилга байгууламжийн эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангах
- ✓ Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах
- ✓ Архаг өвчтэй иргэдийн хяналтыг сайжруулах
- ✓ Ариутгалын чанарыг сайжруулж, стандартад хийцүүлэх
- ✓ Эх хүүхдэд тусламж үзүүлэх, ээлтэй орчин бүрдүүлэх
- ✓ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх, ээлтэй орчин бүрдүүлэх
- ✓ Эрүүл мэндийн төвд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх
- ✓ Багийн эмчийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах
- ✓ Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах
- ✓ Хүлээн авах яаралтай тусламжийн үйлчилгээг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268, А/387/99 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг ссанхүүжүүлэх журам, тусламж үйчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цахир сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд тайлант хугацаанд байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгдсэн журмыг боловсруулан батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Дотоод хяналт шалгалт хийх жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан 10 чиглэлийн хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 439.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 14.7 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Мөнгөн хөрөнгө	0	25.82	25.82	-
Авлага	-	18.58	18.58	-
Бараа материал	60.08	66.83	6.75	11.24
Үндсэн хөрөнгө	292.01	292.6	0.59	0.20
Нийт хөрөнгө	352.09	403.83	51.74	14.70
Өр төлбөр		0	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	352.09	403.83	51.74	14.70
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	352.09	403.83	51.74	14.70

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 25.8 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 18.5 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал эхний үлдэгдлээс 11.2 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 60.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 102.4 сая төгрөг, хандиваар 201.5 сая төгрөг,

нийт 303.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 297.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 66.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 0.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 476.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 2.3 худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 12.3 сая төгрөгийн, иргэн Г.Тэмүүлэнгээс 1.3 сая төгрөгийн, иргэн н.Сэрээнэнгээс 3.5 сая төгрөгийн нийт 17.1 сая төгрөгийн хандив тусламж өгснийг данс бүртгэлд тусгаж, нийт 19.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 203.5 сая төгрөгийн элэгдлээр буурч, 292.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 51.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 51.7 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	65.23	218.56	153.33
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	386.41	427.36	40.95
Нэмэлт санхүүжилт	1.14	167.41	166.27
Орон нутгийн төсвөөс	10.15	11.95	1.80
Үйл ажиллагааны орлого	462.93	825.28	362.35
Цалин, шимтгэлийн зардал	303.36	420.73	117.37
Бараа ажил үйлчилгээний зардал	73.38	298.25	224.87
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29.65	1.08	(28.57)
Бараа үйлчилгээний бусад зардал	36.17	24.08	(12.09)
Урсгал шилжүүлэг	2.80	29.40	26.60
Хөрөнгийн зардал			-
Үйл ажиллагааны зардал	445.36	773.54	328.18
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21.24		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3.67	51.74	55.41

Цахир сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 362.35 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 571.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 131.8 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 439.3 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 439.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 439.3 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн авсан байна. Тайлант онд 439.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 435.3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд мөнгөн хөрөнгийн 4.0 сая төгрөгийг үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 119.4 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 29.4 сая төгрөг нийт 148.8 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан бөгөөд цалин шимтгэлд 69.3 сая, хангамж бараа материалын зардалд 7.8 сая, эмийн зардалд 15.6 сая, хоол хүнсэнд 4.9 сая, мөнгөн тэтгэмжид 29.4 сая төгрөгийг тус тус зарцуулж тайлант оны эцэст 21.8 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цахир сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 283 хүнд үзүүлж ЭМДС-аас 136.4 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 117.8 сая төгрөг авч оны эцэст 18.6 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан.

Цахир сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор давхардсан тоогоор 89 иргэнд ПСР-ийн шинжилгээг, корона вирусын 1-р тунг 1653, 2-р тунг 1640, 3-р тунг 884, 4-р тунг 86 иргэнд дархлаажуулалтын вакцинийг, ковидоор 283 иргэнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг, 7117 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг нийт 11366 иргэнд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан нийт

21 эрүүл мэндийн ажилтанд нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 29.4 сая төгрөгийг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 117 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 435.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.0 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 201.4 сая төгрөгийн бараа материал, 17.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн 6 иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1 тээврийн хэрэгсэлд 17.0 сая төгрөгийн шатахуун, орон тооны 1 жолоочтой, жолоочийн цалинд 8.3 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цахир сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулахаас 151 мэдээллийг хугацаанд бүрэн ил тод мэдээллэж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцэж байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд төсөвт зохицуулалт хийлгүйгээр бараа үйлчилгээний бусад зардлаас 2.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчил албан шаардлага, цалингийн давтан тооцооллоор 1.6 сая төгрөгийн цалин, урамшуулал илүү олгосон зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалин урамшуулал, нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3.2 сая төгрөгийн залруулгын алдаа, 2.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд авлагын дүнг 21.8 сая төгрөгөөр буруу тусгасныг 18.6 сая төгрөг болгон залруулга хийлгэлээ.

4.2 Төлбөрийн акт тогтоох

4.2.1. Цалингийн давтан тооцооллоор Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2 ажилтан дээд шатны даргын тушаал шийдвэргүйгээр хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл болон илүү цагийн хөлс 0.9 сая төгрөгийг, мөн сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 0.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг нийт 1.5 сая төгрөгийн илүү цалин олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

4.2.2. Тээвэр шатахууны үлдэгдэл 1.07 сая төгрөгийн шатахууны толан үрэгдүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Цахир ЭМТ	3	5.7	1	3.2	2	2.5	0	0	0	0
	дүн	3	5.7	1	3.2	2	2.5	0	0	0	0
	Нийт дүн	3	5.7	1	3.2	2	2.5	0	0	0	0